



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 02

Хөхөө

Өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 221 дугаар тогтоол, аймгийн засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/369 дүгээр захирамж, сумын Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/128 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, болзошгүй гамшиг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, иргэн аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах зохион байгууллалтын арга хэмжээ авч төлөвлөн ажиллахыг багийн Засаг дарга, төсөвт байгууллагын дарга эрхлэгч нарт ДААЛГАХ нь:

1.Багийн Засаг дарга нарт

1.1.Багийн түвшинд өвөлжилтийн бэлтгэл ажлыг зохион байгуулах чиглэлээр ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг бүрэн хангах, отрын бүс нутгийн нөөц бэлчээрийн ашиглалт хамгаалалтад анхаарч хяналтандаа авч, отор хийх хүн хүч, малын тоог нарийвчлан гаргаж сум дотроо отроор явах малчин өрхийн судалгааг 9 дүгээр сарын 20-ны хугацаанд мэдээллээ сумын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэнд ирүүлэх.

1.2.Сум хоорондын отроор ирж буй өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тухайн бүс нутгийн бэлчээрийн даацад малын тоо толгойг тохируулах, малын халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэн хяналт тавьж, малчин иргэдэд төрийн үйлчилгээг цаг тухай бүр хүргэх ажлыг зохион байгуулах.

1.3.Малчин өрхөд байгалын хадлан, гар тэжээлийн даалгавар өгч үүний дагуу бүрэн авахуулж мэдээллийг 7 хоног бүрийн “Лхагва” гарагт бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэнд ирүүлэх.

1.4.Байгаль, цаг агаарын аюултай үзэгдэл / үер, усны аюул, мөндөр, хүчтэй шуурга/ - ээс урьдчилан сэргийлэх мэдээллийг цаг алдалгүй багийн малчдад хүргэх.

1.5.Багийнхаа айл, өрхийн орон байрны дулаалга, түлээ, түлшийг сайтар бэлтгүүлж, хашаа гудамжны шарилжийг тухайн эздээр цэвэрлүүлэх.

1.6.Баг бүр өөрийн орон нутгаас отроор явсан малчдад төрийн үйлчилгээ, бусад дэмжлэгийг шуурхай хүргэж, мэдээлж байх.

1.7.Малчин өрх бүрийг малын хашаа, саравч, худаг, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлшээ бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэргээр мал өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулах.

1.8.Малчдын утасны жагсаалтыг шинэчлэн гаргах.

1.9. Намрын ургац хураалтын ажлыг технологийн дагуу цаг хугацаанд нь гаргаж гүйцэтгэж, мэдээллийг 7 хоног бүрийн “Лхагва” гарагт бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэнд ирүүлэх

Энэхүү хийгдсэн ажил, авсан арга хэмжээний тайланг /цаасан хэлбэрээр/ 2021-09-25-ны дотор сумын Засаг даргын орлогч даргад ирүүлэх.

2. Төсөвт байгууллагын эрхлэгч, дарга, захирал нарт

2.1. Байгууллагынхаа өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг хангах, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллах.

2.2. Орон нутгийн нөөц боломжийг ашиглаж аймгаас өгсөн өвс тэжээлийн төлөвлөгөөг бүрэн биелүүлэх, аюулгүйн нөөц бүрдүүлэх зорилгоор төрийн албан хаагч бүр 2 бухал өвсний норм өгч, хүлээн авч нэгтгэн 2021 оны 10 сарын 01-ны дотор сумын онцгой комисст хүлээлгэн өгч шаардлагатай цэгүүдэд байршуулах.

2.3. Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах аймгийн Засаг даргын 2012 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх журмын”-ын дагуу бүрэн хангаж ажиллах.

2.4. Орон нутагтаа болон отроор өвөлжиж хаваржих малчдын талаарх судалгааг үндэслэн нийгмийн болон эрүүл мэндийн явуулын үйлчилгээ үзүүлэх хуваарийг гарган сумын эмнэлгийн бэлэн байдлыг ханган бага насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ялангуяа амаржих дөхсөн болон эрсдэлтэй жирэмсэн эхийг тогтмол хяналтад оруулж, дархлаажуулах явуулын баг ажиллуулах.

2.5. Отроор өөр суманд өвөлжиж, хаваржих малчдад эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ үзүүлэх ажлыг өөрийн болон бусад аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулж, оторлож буй малчдад цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

2.6. Хадлан тэжээл бэлтгэх, ургац хураалтын үед цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулах, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

3. Сумын Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасагт

3.1. Мал сүргийг мал эмнэлгийн намрын арга хэмжээнд бүрэн хамруулж тарилга, туулгалт, мал угаалгын ажлыг чанартай зохион байгуулах

3.2. Намрын ургац хураалтын ажлыг технологийн дагуу цаг хугацаанд нь гүйцэтгэж, мэдээллийг бодитоор гаргаж мэдээлэх.

3.3. Отроор өвөлжих өрхийн малд нэг бүрчлэн үзлэг хийж өрхийн дэвтэр хөтлөх, гоц халдварт өвчний талаар мэдээлэл хийж, зөвлөгөө өгөх.

3.4. Малын төрөл бүрээр, сүргийн зохистой харьцаанд тулгуурлан 2021-2022 онд хэрэгцээлэх, зах зээлд борлуулах малын тоог сумын хэмжээнд нэгтгэн судалгааг 2021 оны 9 сарын 27-ны дотор гаргах

Энэхүү албан даалгаварын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтэнд тогтмол хяналт тавьж, хийсэн ажил, авсан арга хэмжээ, хийх ажлын саналын талаар тайлан, дүнг танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (С.Нямрэнчин), Хөдөө аж ахуйн

тасгийн Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо, бэлчээр газар тариалан хариуцсан
мэргэжилтэн(Х.Насанжаргал) нарт даалгасугай.

ДАРГА



Л.ЭНХЖАРГАЛ